

Монгол Улсын өнөөгийн байдлыг улс төрийн эдийн засгийн ухааны үүднээс эрэгцүүлэх нь

Ч.Өлзийсайхан

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим.

Д.Ундрах

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим.

Хүн төрөлхтөний сэтгэлгээний түүхэнд ямар сургаалиуд хамгийн алдар хүндтэй вэ гэж асуувал бодит амьдралыг хамгийн үнэн зөв, оновчтой илэрхийлсэн онол сургаалиуд л алдар хүндийн оргилд хүрсэн гэж хариулмаар байна. Эдгээр алдартай бүтээлүүд хэдэн зууныг дамжин мөнхөрсөөр байдаг тул тууриван бүтээсэн хүмүүс нь эрдэмтэн мэргэд, сонгодог төлөөлөгчид гэж нэрлэгддэг. Тэдний онол сургаалиуд бүхэлдээ, яг зөв байдаг биш боловч, харин тэдний ихэнхи санаанууд үнэн байдаг гэвэл бодит үнэнд нийцэх бизээ.

Бодит байдлыг гуйвуулсан, худлаа тайлбарласан номлолууд хичнээн өөрсдийгөө сурталчилсан ч алдар нэрийг олж чаддаггүй. Хэдэн зууныг дамжин ирсэн болон өнөө цагт алдар хүндтэй хэвээр байж, улс төрийн эдийн засгийн ухаанд өөрийн байр суурийг баттай эзэлсэн бүтээлүүдэд цаг үеийнх нь бодит байдал хэрхэн тусгагддаг болохыг зах зухаас нь харуулж, тэдгээр байр сууринаас өөрийн орны хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөхийг оролдъё. Бидний энд өгүүлэх зүйл бидний гэхээсээ урьдаар улс төрийн эдийн засгийн ухааны нэртэй төлөөлөгчдийн үзэл санаануудаас хамгийн анхаарууштай хэсгийг нь түүвэрлэн авч өнөөгийн монголын баримтуудаар тэдний үзлийг дахин баталгаажуулж байна гэвэл илүү үнэнд нийцнэ.

Өнөө үед Монгол Улсын төрийн бодлого, хөгжлийн төлөв байдал, ирээдүйн хандлага, эдгээрт хөндлөнгөөс нөлөөлж буй хүчин зүйлүүдийг ойлгох, алдаа гажуудлыг засахад энэ чиглэлийн ажлууд илүү дөхөм үзүүлж болох юм. Монгол Улсад улс төрийн эдийн засгийн ухаан 1990 оноос хойш яагаад хөгжихгүй зогсонги байдалд орчихсон бэ гэдэг учир шалтгааныг хэлж байгаа судлаачид хараахан алга шиг байна. Улс төрийн шинжлэх ухаан тодорхой хэмжээгээр хөгжих хандлагатай, эдийн засгийн шинжлэх ухаан ч өөрийн өнгө төрхөөрөө хөгжиж байгаа ч харин улс төрийн эдийн засгийн шинжлэх ухааны дорвитой бүтээл туурвил гараагүй л байна.

Харин Ф.Энгельсийн бичсэн “К.Марксын “Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь”” хэмээх зохиолын талаархи эрэгцүүллийг унших явцад манай улсад улс төрийн эдийн засгийн ухаан хөгжиж чадахгүй байсны учрыг олоход ихээхэн чухал нэг санааг олсон юм. Хэрэв К.Маркс, Ф.Энгельсийн бүтээлүүдийг иш татах нь хэт хоцрогдсон гэж эргэлзэх хүмүүст хандаж улс төрийн эдийн засаг, социологийн алдар хүндтэй эрдэмтэд Марксыг сонгодог төлөөлөгчийн нэг гэж хүлээн зөвшөөрч түүний олон гайхалтай санааг иш татсан байдгийг энд дурдъя. Тухайлбал, Нобелийн шагналт эдийн засагч Эрнандо дэ Сото “Капиталын нууц. Өрнөдийн ялгуусан капитализм өөр газар өөдлөдөггүйн учир” хэмээх бүтээлдээ “Сайн хийгдсэн өмчийн системийг биширснээр бид энэ систем мөн л хулгай зэлгийг ашиглагдах боломжтой гэдэг Марксын тэмдэглэсэн баримтыг харахгүй өнгөрөх ёсгүй. Дэлхий ертөнц хэзээд, өмчлөх эрхийн цаасыг ашиглан огт сэжиглээгүй хүмүүсийн хөрөнгө, баялгийн өрмийг хуулагч туршлагатай луйварчдаар дүүрэн байх болно”, “Ядуу эдийн засагт явагдсан ихэнхи эдийн засгийг шинэчлэх хөтөлбөрүүд Марксын зөгнөсөн урхинд унасаар байна” гэх мэтээр бичжээ. Иймэрхүү ишлэлийг маш олныг бичиж болох ч гол асуудалдаа эргэн орё.

Ф.Энгельс “К.Маркс. “Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь”” зохиолын тухай бичихдээ “Германчууд шинжлэх ухааны бүх салбарт соёлт бусад үндэстэнтэй эн сацуу, харин ч эдгээр салбарын ихээхэн хэсэгт нь тэднээс давуутайгаа аль хэдийнээ нотлосон юм. Гагцхүү улс төрийн эдийн засгийн ухаан гэдэг зөвхөн нэг шинжлэх ухааны алдартангуудын дотор нэг ч герман хүний нэр байгаагүй юм. Үүний шалтгаан нь илэрхий юм. Улс төрийн

эдийн засгийн ухаан бол одоогийн хөрөнгөтний нийгмийн онолын шинжилгээ мөн болохоор хөгжил бүхий хөрөнгөтний харилцаа тогтсон үед л үүсэн гарах ёстой байв. Иймд Реформацийн ба Тариачны дайнаас хойш, ялангуяа Германд хөрөнгөтний тийм харилцаа үүсч чадахгүй байв. Гэтэл Герман дахь хөрөнгөтний материаллаг хөгжлийг 1830 он хүртэл дөнгөлөн боож байсан дундад зууны үеийн инээд хүрэм ужиг үлдэгдлийн эсрэг тэмцэх ёстой болж байсан тэр үед Германы улс төрийн эдийн засгийн ухаан үүсэх бололцоо байсангүй. Зөвхөн “Гаалийн холбоо байгуулснаар л германчууд улс төрийн эдийн засгийн ухааныг ерөнхийд нь ойлгох төдий байдалд хүрсэн юм” гэжээ. Энэ ишлэл Монгол Улсад улс төрийн эдийн засгийн ухаан өнөөг хүртэл дорвитой хөгжиж чадахгүй байгаа нь энэхүү капиталист харилцаа хөгжих эхлэлийн шатандаа байсантай холбоотой, энэ харилцааны сөрөг талуудыг олж харах боломж хараахан бүрдээгүй байсан байх магадлалтай гэсэн санааг шууд л төрүүлж байна. Үүнийг эсэргүүцэх хүмүүс байж болох ч үүнийг бичиж буй бид ийм л байх гэдэгт нэг их эргэлзэхгүй байна.

Онол сургаалиуд цаг үеийнхээ л тусгал байдаг, бодит байдлыг харахгүйгээр агуу онолууд гарах боломж тун бага. Эрдэмтэн мэргэд бодит байдлыг л үнэн зөв харж, үнэн зөв тайлбар хийж, асуудлын мөн чанарыг илүү тодорхой харж, илүү хөдөлмөрлөж чадсанаараа л алдар хүндийн оргилд хүрсэн. Аль нэг үзэл суртлыг зориудаар хамгаалах гэж тэд өөрсдийн номлолоо бичиж тууриваагүй гэдэг нь дийлэнхи болов уу. Онол сургаалиуд цаг үеэ л тусгаж байсан тухай олонтоо нуршаад байгаагийн учир нь, бид өнөөгийн монголын нийгэм эдийн засагт огт тохирохгүй, жирийн хүний нүдэнд ч ил байгаа зүйлийг системтэйгээр эсэргүүцдэг, хэвлэл мэдээлэл, оюун санааны баялгийг өөрсдийн захиалгаар өнгөлөн бүдгэрүүлж байдаг, эрх мэдлийн хувьд хүчирхэг хүмүүс цөөхөн ч гэсэн байдаг, гэхдээ цөөхүүлээ ч нөлөөлөл нь дэндүү их учраас тэдний өгүүлж байгааг няцаахын тулд энэ санааг дахин дахин хэлээд байгааг цаашид ойлгох болно.

Улс төрийн эдийн засгийн ухааны хамгийн анхны томоохон бүтээл Адам Смитийн “Үндэсний баялаг” бүтээл ямар цаг үеийн тусгал болж гарч ирсэн болохыг авч үзье.

Адам Смитийн бүтээл гарах үе бол Английн улс төрийн болон эдийн засгийн ихээхэн хүнд үетэй холбоотой байдаг. Англи улс “Франц Индианы дайн” буюу 7 жилийн дайны дараа эдийн засаг нь ихээхэн сульдан доройтож үүний улмаас колонийн талаар бодлогодоо ихээхэн өөрчлөлт оруулж эдийн засгаа өөд нь татах эх үүсвэрийг колониудаа гэж үзжээ. Харин Америкчууд, тэнд төрж өссөн үндэсний сэхээтнүүд, сэтгэгчид, тэмцэгчид колонийн бодлогыг ихээхэн эргэцүүлэх болсон байна. 1764 онд “Чихрийн хууль”, 1765 онд “Тамганы тухай хууль”, 1767 онд “Тауншэндийн хууль” мөн 1773 онд “Tea act” хэмээх хуулиудыг батлаж Английн засгийн газарт колонийн зүгээс төлөх татварын хэмжээг үлэмж нэмэгдүүлж, колонийнхон Англиас өөр газраас бараа оруулах, өөр улсын усан онгоцоор тээвэр хийхийг хориглосон зэрэг нь колонийн үйлдвэр худалдааныхны дургүйцлийг төрүүлжээ. 1773 онд Ост Индия компанийн 342 авдар цайг далайд хаяж хохирол учруулсан байдаг. Америкт очиж суурьшсан иргэдийн үндэсний ухамсар гүнзгийрч Английн колоничлолоос бүрэн чөлөөлөгдөх, тусгаар тогтнох шаардлагатай гэж үзэж Самуэль Адамс, Александр Хамилтон, Томас Жеффэрсон нар тэмцлийг манлайлж байв. 1774 оны 9 сард Умард Америкийн колонийг төлөөлсөн 56 төлөөлөгч Филадельфид цугларч Тивийн анхны Их хурлыг зохион байгуулж хурлаас Английн эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авах шийдвэр гаргажээ. Мөн “Эрхийн тунхаглал” Bill of Rights хэмээх бичгийг батлаж, тэмцэгчид Английн колоничлогчдын эсрэг зэвсэг барин тулалдах болсон. Умард Америкийн колониуд биеэ даасан Нэгдсэн улс байгуулахаар шийдвэрлэж 1776-7-4-нд Тусгаар Тогтнолын тунхаг бичгийг батлан гаргасан байдаг.

Тэгвэляг энэ үед, энэ томоохон тэмцэл хөдөлгөөнүүдтэй зэрэгцэн 1776 онд Англид АНУ-ын Тусгаар тогтнолын тунхаг бичгээс дутахааргүй ач холбогдол бүхий ном хэвлэгдэн гарсан нь Гласгоугийн их сургуулийн эрдэмтэн Адам Смитийн бичсэн “Үндэстний баялагын мөн чанар, учир шалтгааны лавлагаа” хэмээх ном байв. Энэхүү ном нь баялаг бүхий шинэ ертөнц бий болгох тухай, энгийн ажилчныг дарлалаас ангижруулах, эдийн засгийн бие даасан байдлыг тунхаглах боломж олгосон. Мөн энэ үе нь аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийн үетэй

давхцаж таардаг бөгөөд ном гарснаар эдийн засаг нь өссөн юм уу, эсвэл эдийн засаг нь өссөнөөр ном нь гарсан юм уугэж эргэлзмээр ч санагддаг. 1776 он бол хүн төрөлхтөнд эргэлт авчирсан жил болох нь харагдаж байна. Энэ онд эдийн засгийн эрх чөлөөг ч тунхагласан, улс төрийн эрх чөлөөг ч тунхагласан. Энэ үеэс аж үйлдвэржилтийн хувьсгал ч эхэлсэн. Английн эдийн засагч Алфред Маршаллын хэлсэнчлэн “эдийн засгийн ухаан бол амьдралын энгийн үйл хэргийг л судладаг”-ийн нотолгоо юм бол тухайн цаг үе, эдийн засгийн эрх чөлөөний төлөөх америкчуудын тэмцэл нь улс төрийн эрх чөлөөгөө олж авахын төлөөх тэмцэл болон өрнөсөн цаг үе нь Адам Смитийн алдарт бүтээл гарч ирэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болох нь тодорхой. Тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал, түүний учир шалтгааныг энэ суут эрдэмтэн өөрийн бүтээл тууривалдаа тусгах нь эргэлзээгүй зүйл билээ.

Хэдийгээр Адам Смитийн бүтээл тухайн цаг үеийнхээ тусгал болж баялаг бүтээх арга замыг маш нухацтай зааж өгсөн нь гарцаагүй үнэн боловч энэ сургаал нь үргэлж мөнхөд, бүх цаг үе, бүх нөхцөл байдалд тохирно гэсэн ч үг биш юм. Тэр цаг үедээ ч эргэлзэж, үл итгэж байсан болохыг улс төрийн эдийн засгийн ухааны бас нэг нэрт төлөөлөгч Бастиа бичиж үлдээсэн байдаг.

“Мөнхийн хөдөлгүүр, философийн чулуу, тойргийн дөрвөлжин гэх мэтийн будлианууд хүн төрөлхтөний оюун ухааныг эзэмдэхээ больчихоод байхад дээрмийн аргаар хөгжих сэтгэлгээний онол өнөөг хүртэл үнэ хүндтэй хэвээрээ л байгаад байдаг байна шүү. Гэтэл энэ мэтийн хүүхдийн тоглоом шиг ажлууд хамгийн богино настай байж болохыг төрөлхийн совин шивнээд байгаа юм даа. Олон хүн намайг “та чинь “Laissez passer”-ийн (Laissez Faire) талын хүн юм шив дээ?” хэмээн хоргоодог. “Та бол аль хэдийн хуучирсан Смит, Сей хоёрын сургуулийн эдийн засагч гэж муулдаг. “Та хөдөлмөр зохион байгуулалтыг эсэргүүцдэг үү?” гэж асуудаг. Ноёд оо, та нар л өөрсдөө хөдөлмөрөө зохион байгуулцгаа. Харин бид таануусын дээрэм зохион байгуулахгүй талаас чинь л хянаж байя”¹⁴⁵

гэж бичиж үлдээжээ.

А.Смит ч Бастиа ч тухайн цаг үеийнхээ илэрхийлэл болж хөгжлийг хангаж болох хамгийн боломжит аргыг зааж байсан. Гэхдээ онол бүхэн хамгийн гол үзэл санаа нь үнэн зөв, үнэ цэнэтэй байдаг боловч энэ нь цаг үе бүхэнд яг үргэлж нийцдэг биш, тодорхой нөхцөл байдлыг харгалзан үзэж зөв зүйтэй зохицуулах нь гарцаагүй шаардлагатай болохыг Нобелийн шагналт эдийн засагч Э.Сото өнөө цаг үед дээрх хоёр суут хүмүүсээс арай өөрөөр харж байгаагаар нотлож болно. Э.Сото “Капиталын нууц. Өрнөдийн ялгуусан капитализм өөр газар өөдлөдөггүйн учир” бүтээлдээ “Коммунизмыг ялснаар капитализмын эдийн засгийн дэвшлийн талаархи хуучин хэлэлцэх асуудал барагдсан бөгөөд одоо өөр сэдэв хэрэгтэй байна. Явагдаж буй эдийн засгийн шинэчлэлүүд зөвхөн цөөн даяарчлагдсан элитэд үүд хаалгаа нээж хүн төрөлхтөний ихэнхи хэсгийг гадаа нь орхиж байгаа баримтыг орхигдуулан нээлттэй эдийн засгийг уриалсаар байх нь одоо утгагүй юм” гэжээ¹⁴⁶.

Мөн түүнчлэн янз бүрийн ашиг сонирхлоос үүдэлтэйгээр зарим номлол сургаалийг маргашгүй үнэн гэж хэт дөвийлгөн номлож, нийгмээрээ цээжилж тогтоох, өөр эрэгцүүллийг нийгмийн эсрэг зүйл гэж үзэх хандлага хүн төрөлхтөний түүхэнд их бий. Энэ байдал нь эрх мэдэл, мөнгө төгрөгтэй хүмүүсийн ашиг сонирхолд нийцэж байвал бүр ч давашгүй хүчин зүйл болон бэхжиж байдаг учраас улс төрийн эдийн засгийн ухаан жинхэнэ бодит үнэнийг харуулах хүртлээ ихээхэн зовлон туулах нь гарцаагүй юм. Монгол Улсад өнөөдөр байгаа Улс төрийн эдийн засгийн ухааны хөгжил ч энэ жамаас гажаагүй, гэхдээ л үнэнд гарцаагүй гүйцэгдэж ирж байна.

Нийгмийн түүхгүйгээр улс төрийн эдийн засгийн ухааны түүхийг бичиж болохгүй. Энэ шинжлэх ухааныг тааварлан бичиж болохгүй бөгөөд үнэн зөв, мөн чанарыг нь олж харах арга нь түүхэнд суурилсан, санамсаргүй тохиолдлоос ангижирсан, логикийн хувьд зөв байх ёстой.

¹⁴⁵Фредерик Бастиа. “Ил харагдах, үл харагдах УБ., 2014, 183 дахь тал

¹⁴⁶Эрнандо дэ Сото. Капиталын нууц. Өрнөдийн ялгуусан капитализм өөр газар өөдлөдөггүйн учир. УБ.2003. 213 дахь тал.

Өнөөдөр улс төрийн эдийн засгийн ухааныг монголынхоо хөрсөнд буулгаж судлахад түүхээ дагасан сэтгэхүйд тулгуурлах ёстой болохоос биш хийсвэрлэж, хэн нэгний бодож сурталчилсан янз бүрийн онолыг дагаж замаа алдах хэрэггүй. Түүхэн үе бүрийн хөгжлийн түүхийг эрэгцүүлж, өнөөгийн бодит байдал, үр дүн, цаашдын хандлагыг нь бодитойгоор олж харахад л улс төрийн эдийн засгийн ухааныг хөгжүүлэхийн утга учир нь оршино.

Монгол Улсад зах зээлийн эдийн засаг, чөлөөт өрсөлдөөн гэж зүйлийг үнэхээр ямарч өрсөлдөөнгүй ганц зөв номлол гэж үзэж түүнд ядахдаа эргэлзсэн хэн нэгнийг хамгийн хоцрогдсон нэгэн болгож гутаан доромжилж байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эдийн засгийн ухааны олон эрэгцүүлэл, үнэнийг хайх тэр шинжийг ганцхан цонхоор харуулах гэсэн асар том хүчирхэг үзэл суртал марксизм гэсэн номлолын оронд ноёрхох болсон билээ. Фредерик Бастиа “Ил харагдах, үл харагдах” хэмээх алдарт бүтээлдээ нийгмийн сэтгэл зүйг мунхаруулах замаар төөрөгдүүлж хууран мэхэлж тэднийг мөлжиж болдгийг их тодорхой өгүүлсэн байдаг. Тэрээр бичихдээ:

“Чамд би асар их тус хүргэнэ, гэхдээ энэ ертөнцөд байхад чинь биш, нөгөө ертөнцөд очсон хойно чинь. Жаргах, зовох чинь зөвхөн надаас шалтгаална. Би бол Бурхан, хүн хоёрыг холбон зуучлагчтул диваажингийн хаалга, тамын хаалга хоёрын алийг нь нээхээ мэднэ” гэх юм бол надад итгээд, миний гарт орчихно.

Мэхтнүүд хэрхэн зорилгодоо хүрдэгийг ойлгохын тулд өөрийгөө тэдний байранд тавиад үз. Хэрвээ би энэ зорилгоор харанхуй бүдүүлэг хүмүүсийн дунд ороод жирийн бус, бүр дээд тэнгэрийн ч байж болох бодьгаль байна гэж төсөөлбөл өөрийгөө бүх хүмүүсийн хувь заяаг шийдвэрлэх эрхтэй Бурханы элч гэж зарлах байсан. Тэр нөхцөлд оюун ухаан л миний аюултай дайсан болох тул хамгийн түрүүнд түүнийг ашиглахыг хориглож, түүнтэй холбоотой бүхий л зүйлд хориг тавина. Түүнд хариу өгөх, түүний талаар асуух, тэр ч байтугай бодох нь наад захын гэмт хэрэг байх болно. ...Аливаа эргэлзээг ч бурханы эсрэг зүйл гэж зарлаваас өөрийгөө илчлүүлэхгүй байх хамгийн мэргэн шалгуур болно. Би... оюун ухааныг хэзээ ч олон түмэнд нэвтрүүлэхгүй, өөртөө болоод хамтран зүтгэгчиддээ шинжлэх ухааны монополь олгож,... болзошгүй дайралтаас урьдчилан сэргийлэхийн тулд хүн бүрийн оюун бодлын нууцад нэвтэрч чадах чадвар олгох тийм нэг хүрээлэнг өөртөө зориулж байгуулна. ...Ингэснээр би ард түмнийхээ оюун ухаан, сэтгэл зүрхийг хүссэнээрээ жолоодох болно. Миний нэр хүнд, ард түмний ёс суртахуун хоёр салшгүй холбоотой байх тул нэг нь нөгөөгүйгээрээ оршин тогтнох боломжгүй гэдгийг зарлаж, хэн нэгэн үүнийг маань зөрчвөл бүх нийгэм (ёс зүйгүй байж чадахаа байсан тэр нийгэм) донсолгоонд орж, уг тэрс үзэлт шинэчлэгчдэд хамаг хилэнгээ гаргах болно. Хэрвээ би үүнийг хийж чадвал хүмүүс миний боолууд байснаас хамаагүй өөр түвшний өмч маань болно. Ингэснээрээ би боолын тамгыг духан дээр нь биш, харин оюун ухаан, зүрх сэтгэл дээр нь дарна” гэжээ.

Бастиагийн өгүүлснийг уншихаар зах зээлийн эдийн засаг бүхнийг зохицуулах тухай, төр хамгийн муу менеджер байх тухай, төрийн өмчийг хувьчилж байж л улс орон хөгжих тухай, чөлөөт өрсөлдөөн л ганц зөв сонголт байх тухай өнөөгийн нийгэмд эцэс төгсгөлгүй номлодог мөртлөө энэ бүхэн нь амьдралд ерөөсөө авцалдахгүй байгаа дүр зураг шууд бууж ирнэ. Улс төрчдийн амнаас гардаг, бодит байдалд ард түмэнд үр ашгаа огт өгөхгүй байгаа эдийн засгийн энэ номлолыг эргэж харах, эрэгцүүлэх ёстой гэж юуны өмнө бодогдоно. АНУ-ын улс төрийн эдийн засгийн эрдэмтэн Питер Грей дэлхийчлэгдэж байгаа орчин үеийн ертөнцөд ухаалаг улс төр эдийн засгийн бодлогогүйгээр хөгжиж буй улс орнууд ихээхэн хохирол амсч байдаг талаар бичсэн нийгмийн манай улсын хувьд ихээхэн анхаарах ёстой гэж үзэж байна. Тэрээр “дэлхийн II дайны дараа хүртэл колони байсан улс орнууд эсвэл эдийн засаг нь гадаад улс орнуудаас ихээхэн хамааралтай байдаг улс орнууд үйлдвэрлэлийг нь гадаад улс орнуудаас удирдахад ихээхэн ихээхэн эмзэглэн хүлээж авдаг. Үндэстэн дамнасан корпорацуудыг эрс эсэргүүцэгчид үүнийг шинэ колоничлол гэж үздэг. Хөгжиж байгаа эдгээр улс орнууд нь өөрийн орны ард иргэд, байгууллага, засгийн газартаа болж өгвөл хамтарсан аж ахуйн нэгж байгууллагуудынхаа 50%-ийг эзэмшүүлэх гэж оролддог. Ийм хамтарсан байгууллага, аж ахуйн нэгжүүд олширч байна. Гэвч энэ нь бодит амьдрал дээр хийсвэр зүйл болж байдаг. Учир нь үндэстэн дамнасан корпорацууд ихэвчлэн олон гэрээ хийдэг бөгөөд эдгээр гэрээнүүд нь тэднийг хувьцааны оролцоог нь олон янз байдлаар хязгаарлачихсан

байдаг”¹⁴⁷ гэж бичжээ. Энэ нь аливаа улс орнууд, ялангуяа хөгжиж байгаа улс орнууд эдийн засгийн бодлого явуулахдаа улс төрийн хувьд хүчирхэг, алсын хараатай бодлого явуулахаар байх ёстойг өгүүлж байгаа хэрэг юм..

“Шударга бус үйлийн сүрт барилгыг нураах нь зөвхөн олон нийтийн санаа бодлоор шийдэгдэх бөгөөд, хэрэв тэр барилгын тоосго бүр нь хяналтанд орчих юм бол олон нийтийн санаа бодол гэж юм байхгүй болно шүү дээ. Энэ бол цаг хугацаа, хэвлэлийн суурь машин хоёрын л хийх ажил. Түр зуурын зовлонд нэрвэгдсэн энэ амьдрал нь ирээдүйн аз жаргалтай амьдралын дохио гэдгийг би Бурханы өмнөөс батлах ёстой. ... гэж Бастиа бичиж байж. Үнэхээр өнөөгийн монголын нийгэмд чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах, төрийн оролцоог нэмэгдүүлэх, төр ухаалаг менежмент хийх бололцоотой гэх мэтээр ярих юм бол нийгмээрээ үзэн ядах хэмжээнд, ардчиллыг сөнөөх гэж байгаа нэгэн мэтээр ад үзэгдэж эхэлнэ. Өөрөөр хэлбэл, оновчтой бус төрийн тогтолцоог ашиглан нийтийн баялгыг завшиж авсан хэсгийнхэн өөрсдийн өмчлөлд байх хэвлэл мэдээллийг ашиглан нийгмийн тархинд суулгаж өгсөн тэр санаа бодол нь бодит байдлыг эрэгцүүлэн бодох гэсэн нэгэнд боломж олгохгүй болохыг 200 жилийн өмнө амьдарч байсан суут хүн олж харж л байж. Тийм учраас өнөөдөр бид улс төрийн эдийн засгийн ухааныг нухацтай шинжлэн судлах гарцаагүй шаардлага бий шүү гэдгийг л ойлгуулахын тулд хамгийн алдар цуутай эрдэмтэд суут хүмүүсийн бүтээлүүдээс иш татан өөрсдийгөө хамгаалуулах гээд байгаа хэрэг юм.

Биднийг гадаадын хөрөнгө оруулалт, өр зээлгүйгээр амьдрал байхгүй гэж номлож байхад Нобелийн шагналт эдийн засагч Эрнандо дэ Сото ихээхэн өөр зүйл өгүүлж байгааг хэрхэн ойлгох вэ? Тэрээр

“Анзаараагүй байгаа хүмүүст хэлэхэд, капитализм ба даяарчлалын эсрэг зэвсэг хуралдаж байна. Өнөөдөр капитализмыг эсэргүүцэгчдэд өчүүхэн дарь нэмэхэд л, капитализм бол өмчийг ядуу орноос баян руу зөөвөрлөх гэсэн үг бөгөөд хөгжиж буй орнуудад хийгдэж байгаа Өрнөдийн хувийн хөрөнгө оруулалтууд бол зөвхөн олон орнуудад байгаа салбаруудаараа дамжуулж тэдний нөөц баялгийг бөөнөөр нь өөрийн хяналтанд авч байгаа явдал гэж нотлоход бэлэн байгааг буурь суурьтай статистик харуулж байна”¹⁴⁸

гэж өгүүлж байна. Одоогоор аль нэгнийг нь дагнан зөв гэж хэлэх хэцүү. Харин аль нь зөв бэ гэдгийг шийдэхэд олон хувилбар бүхий санаануудыг бодит байдалтайгаа холбон авч үзэх нь л чухал юм. Бид эрх мэдлээр дамжуулан хэн нэг нь бусдыг, олон түмнийг дээрэмдэхгүй байлгахын тулд чин үнэнийг л мэдэж авах ёстой. Өөрөөр хэлбэл, улс төрийн эдийн засгийн ухааны хэн нэгний номлолыг яг үнэн гэж хуулбарлан дуурайх биш, харин тэдгээрийг бодит амьдрал дээр тулгуурлан нарийн судлах, утга учрыг нь тунгаах шаардлагатай л гэсэн үг.

Мөн түүнчлэн иргэний нийгэм амжилттай хөгжиж байгаа юу, эсвэл дүр эсгэж байна уу гэдгийг улс төрийн эдийн засгийн ухааны үүднээс л харвал зохих юм. Улс төрийн эдийн засгийн ухааны үнэнд нийцсэн, зөв мэдлэгтэй болж чадвал нийтийн баялгийг дээрэмдэгчдийн аюулаас хол байж чадна, бидний энэ гэгээрэл нь хуурч мэхлэх аргыг л үндэсгүй болгоно гэсэн үг юм. Нэг хүнд оногдох байгалийн баялгийн нөөцөөрөө дэлхийд эхний аравт ордог мөртлөө иргэдийн сайхан амьдралыг хангаж чадахгүй, үйлдвэрлэх хүчээ хөгжүүлж чадахгүй, өр зээлэнд баригдаж ирээдүй бүрхэг харагдаж байгаа нь төрийн бодлого нь улс төрийн эдийн засгийн ухааны үүднээс бол буруу байгааг л нотлон харуулах бөгөөд үүнийг засахыг хүссэн нийгмийн хүсэл дэндүү их болсон нь төрийн бодлого зөв гардаг тэр тогтолцоог бий болгох, засч өөрчлөх процесс нэгэнт эхэлсний дохио юм.

¹⁴⁷ H. Peter Gray. *International Economic Problems and Policies*. NY., 1987.

¹⁴⁸ Эрнандо дэ Сото. Капиталын нууц. Өрнөдийн ялгуусан капитализм өөр газар өөдлөдөггүйн учир. УБ.2003. 213 дахь тал.

Зах зээлийн харилцаа бүхнийг гоё болгоно гэсэн яриа, даяарчлагдсан энэ дэлхий ертөнц аяндаа ядуу буурай улс орнуудыг хөгжүүлнэ гэсэн хоосон яриа дэлхийг бүхлээр нь сайхан болгохгүй гэдэг нь нэгэнт ойлгомжтой байгаа бөгөөд, гагцхүү түүхэн процесс бүрийн утга учир, үр дүнг ухаалгаар харж байж л тийм зорилтыг биелүүлж чадна. Өнөөдөр гарч байгаа улс төрийн үйл ажиллагаа, төр засгийн шийдвэрүүд шийдвэр гаргагчдад хамааралтай материаллаг учир шалтгаан ихтэй байгаа нь илт харагддаг бөгөөд улс төрийн болон хууль эрх зүйн байдал ч гэсэн ийм материаллаг нөхцөл байдалтай нягт холбоотой л явагдаж байна.

Зах зээлийн эдийн засгийн үл үзэгдэх гарт бүхнийг даатгаж дэлхий нийтийн хэмжээний хөрөнгө оруулалтыг амь тариа шигээ үзэх болсон төрийн бодлого нь энэ үзэл санааг анх түрүүн гаргаж ирсэн эрдэмтдийнхээ үзэл баримтлалтай хэрхэн нийцдэг юм бэ гэдгийг Адам Смитийн “Үндэстний баялаг”- д хэрхэн өгүүлснийг харья. Тэрээр

Аливаа хөрөнгө өгөөжтэй хөдөлмөрийг л тэтгэхэд зориулагдах учиртай авч, хэмжээгээрээ ижил хөрөнгийг хөдөлгөөнд оруулдаг хөдөлмөрийн хэмжээ нь хэрэглэж байгаа аргаасаа хамааран ихээхэн хэлбэлзэх бөгөөд, үүний хамтаар тэдгээрийг хэрэглэснээр улсын жилийн нийт бүтээгдхүүнд орох өртөг нь бас өөрчлөгдөж байдаг.

Хөрөнгийг нэгд, жил бүр нийгмийн хэрэглээнд шаардагдах түүхий бүтээгдхүүнийг олборлох, хоёрт, мөнөөх түүхий бүтээгдхүүнийг шууд хэрэглээнд тохирохуйцаар боловсруулах, гуравт, түүхий ба боловсруулсан, бэлэн бүтээгдхүүнийг илүүдэлтэй газраас дутагдалтай газар руу тээвэрлэх, дөрөвт, мөнөөх бүтээгдхүүнүүдийг хэрэглэгчдийн хэрэглээнд тохирсон хэмжээгээр жижиглэн хуваах гэх зэрэг 4 аргаар хэрэглэж болдог. Газар боловсруулж, элдэншүүлэх, уул уурхайн болон загас агнуурын үйлдвэрлэл эрхэлж байгаа бүхэн хөрөнгөө эхний аргаар, мануфактур үйлдвэрлэл эрхлэгчдийн хөрөнгө хоёр дахь аргаар, бөөний худалдаачдынх гурав дахь аргаар хэрэглэгдэж байгаа юм. Эдгээрт орохгүй өөр аргаар хөрөнгийг ашиглана гэж байхгүй.

Хөрөнгө оруулалтын энэ дөрвөн хэлбэрийн аль нь ч гэсэн нөгөө гурвынхаа орших, өргөжихийн үндэс болж нийгмийн хөгжилд зайлшгүй нөлөөлнө¹⁴⁹

гэжээ. Монгол улсын эдийн засаг бараг бүхэлдээ уул уурхайгаас хамааралтай байна. Гэтэл Адам Смитийн нийгмийн баялгийг бий болгож байдаг, бие биенийгээ орших эс оршихыг нь нөхцөлдүүлж байдаг дээрх дөрвөн аргыг хэдийг нь манай төр бодитойгоор хэрэгжүүлж байна вэ. 1 дэх олборлох арга нь дэндүү сайн байна. Түүнийг боловсруулахыг нь өөр улс оронд хийдэг. Тэр шатны баялаг нь монгол улсад ямар ч ашиг тус өгөхгүй. Тээвэрлэлт нь бүтээгдхүүн үйлдвэрлэж нийгмийн хэрэгцээг хангаж түгээх маягаар нийгмийн баялгийг ари्वжуулах биш харин уурхайгаас хил хүртэлх зайны хамгийн бага хэмжээний тээвэрлэлтээс л өчүүхэн ашиг олж, тээвэрлэлтээс олох бусад бүх ашиг монголын хийлийн чанадад үлддэг. Дөрөв дэх бүтээгдхүүнийг жижиглэн хувааж худалдаалж нийгмийн баялгийг ари्वжуулах гэдэг нь мөн л аль хэдийн монголынх биш болчихсон байх тул огт бидэнд хүртээлгүй зүйл болжээ. Энэ бол улс төрийн эдийн засгийн ухааны хамгийн анхан шатны А үсэг бөгөөд аль эрт 1776 онд хүн төрөлхтөн мэддэг болчихсон зүйл юм. Харин улс төрийн эдийн засгийн ухаан хөгжөөгүй, эдийн засгийн шинжлэх ухааны төлөөлөл нь дангаараа улс төрийн шийдвэр гаргагчдын талд үйлчилж байгаа учраас энэ шинжлэх ухааны хамгийн анхан шатны шаардлагыг ч хангаж чадахгүй төрийн бодлого 27 жил үргэлжилж улс орны эдийн засаг, ард түмний аж байдлыг тулдуулж байна. Иймд бид эдийн засгийн ийм буруу шийдвэр яагаад гардгийн улс төрийн цаад мөн чанарыг ил гаргаж нийгмээрээ гэгээрэхгүйгээр байдлыг өөрчлөх боломжгүй. Үүнд л улс төрийн эдийн засгийн ухааныг хөгжүүлэхийн амин чухал хэрэгцээ шаардлага оршиж байна.

Адам Смит улс үндэстний хөрөнгө нь хувь хүмүүсийн хөрөнгийн адил орлогоосоо хэмнэсэн зүйлээ хуримтлуулж байж л өснө. Иймээс аливаа улсын улс төрийн эдийн засгийн

¹⁴⁹ Адам Смит “Үндэстнүүдийн баялаг.” УБ., 2009, 370 дахь тал

гол зорилго бол улсынхаа баялгийг нэмэгдүүлэж, хүчирхэг болгох явдал байх ёстой¹⁵⁰ гэж үзэж байсан. Харин өнөөгийн Монгол Улс маш их байгалийн баялгийг гадаадад гаргаж байгаа ч нөгөө хуримтлуулах ёстой орлого нь гадаад компанийн гадаадад байгаа данс руу ордог, тэндээс зуучлах замаар ашиг олсон улс төрчдийн орлого нь оффшорт байрлачихаар Адам Смитийн үл үзэгдэгч баялаг бүтээгч гар нь Монгол Улсыг баяжуулах гэдэг хэзээ ч бүтэхгүй зүйл болчихож байна.

Худалдаанд гадаад дотоодын аль нэг талд нь давуу эрх олгож болохгүй гэж үзэж байсан үзэл баримтлал нь капитализмын хөгжлийн эхэн үеийн онцлог, мөн АНУ байгуулагдаж байх үед Эзэнт гүрэн, шинэ колони хоёрын эдийн засгийн ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй улс төрийн томоохон үйл явдлууд болж байсны л тусгал юм. Харин өнөөдөр яг ийм байдлаар чөлөөт өрсөлдөөнөөр явуулах нь хөгжиж буй улс орнуудад хохиролтой, өндөр хөгжилтэй улс орнуудад л ашигтай юм. Үүнийг бид тооцож ажиллахгүйгээр эдийн засгийн хөгжлийн тухай ярихгүй юм.

Нэгэнт либерал үзэл баримтлалынхны номлодог шиг хил хязгааргүй нэг дэлхий бий болчихоогүй, улс үндэстэн бүр өөрийн гэсэн хил хязгаар, ашиг сонирхолтой хэвээр байгаа нөхцөлд ухаалгаар амиа бодох зарчим нь давуутай үйлчлэх ёстой. Иймд улс үндэстнийхээ эрх ашгийг өнөөдрийн бодит байдалд уялдуулан зохицуулж явуулах нь чухал болохоос биш хэзээ хэрэгжих нь мэдэгдэхгүй” бурханы мөнхийн сайхан сэтгэлд” итгэж дэндүү гэгээлэг улс төрийн эдийн засгийн бодлого явуулах нь нийгмийн нэг цөөхөн хэсэг л нийтийн баялгийг залилан дээрэмдэхээс өөр юунд ч хүргэхгүй. Ард түмний хөдөлмөрч чанар биш харин төрийн бодлогын аригч хямагч чанар л улсын хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ. Ард түмний хүч хөдөлмөрөөр олдож байгаа баялгийг хямагдаж хэмнэж чадахгүй бол улс орны хөрөнгө чинээ хэзээ ч өсөн нэмэгдэхгүй. Нийгмийн хөрөнгийг хямгатай ухаалаг зарцуулбал аривждаг, хүний сэтгэлээр үрэлгэн загнавал хэзээ ч аривждаггүй, орлого зарлага нь тэнцэж байвал аривжих ч үгүй, багасах ч үгүй гэдгийг улс төрийн эдийн засгийн сонгодог төлөөлөгчид хэдэн зууны тэртээд хэлчихсэн зүйл юм.

Баялгаа зарж олсон орлогоо улс орондоо оруулж ирж, баялгийн сандаа хуримтлуулж нийтээрээ хэлэлцэж зарцуулбал аривжина, баялгаа зарчихаад мөнгө нь дэлхий даяар тараад эргэж монголдоо орж ирэхгүй бол хэзээ ч арвижихгүй, харин ч хөрсөн бор байгаад гараад явчихсан баялгийн хэмжээгээр улсын сан хөмрөг дундарна, амиа аргацаасан бодлого явуулбал өнөөгийн байдалдаа үлдэнэ гэдгийг сонгодог төлөөлөгч ч гэхгүйгээр энгийн хүний ойлгох зүйл юм. Харин үүнийг олон тооны тоо, цифрээр далайлган өөрөөр тайлбарлаж, хохироож байгаа нь бас нь улс төрийн эдийн засгийн ухаан байх бөгөөд гэхдээ энэ нь ард түмний тусын тулд биш харин цөөн хэдэн хүн нийтийн баялгийг цөлмөхөд үйлчлэх улс төрийн эдийн засгийн ухаан юм.

Либерал эдийн засгийн онолын үүднээс бол зах зээлийн эдийн засаг нь хөгжлийг хангах ганц түлхүүр юм бол үүнийг тууштай хэрэгжүүлээд байгаа мөртлөө улс орнууд яагаад өөр өөр үр дагаварт хүрээд байгаа юм бэ, энэ номлол ёсоор бол төр оролцохгүй орхиход л хүмүүс өөрсдөө зохицуулах ёстой шүү дээ. Үүний учир шалтгааныг олж тайлбарлах гэсэн эрдэмтэн судлаачид цөөнгүй. Одоо дэлхий дээр чөлөөт зах зээлийн эдийн засгийг хүлээн зөвшөөрөөгүй улс гэж бараг үлдээгүй. Куба, Хойд Солонгост л энэ байдал хагас хугас үлдэж хоцорсон болов уу. Гэтэл чөлөөт зах зээлийн эдийн засаг бүх зүйлийг сайхан болгож, хөгжлийг хангаж чаддаггүй болохыг дэлхийн 200 гаруй улс орнуудын хөгжлийн түвшин, иргэдийн амжиргааны түвшин, тэдний ирээдүйн асуудал илхэнээ харуулна.

Тэгвэл зах зээлийн эдийн засаг яагаад ийм өөр өөр үр дагаварт хүргэж байгааг учир шалтгааныг бид өөр зүйлээс хайх болж байна. Юуны өмнө энэ учир шалтгааныг тайлбарлаж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэд болох Дарон Ажэмоу, Жеймс А.Робинсон нарын томоохон бүтээл бий. Тэдний номын тухай:

¹⁵⁰ Адам Смит “Үндэстнүүдийн баялаг.” УБ., 2009, 378дахь тал

“Улс үндэстний уналт доройтлын шалтгаан” үнэхээр гайхалтай бүтээл. Ажэмолу, Робинсон нар олон зууны туршид аугаа сэтгэгчдийн зовоож байсан нийгмийн шинжлэх ухааны хамгийн чухал асуудлын нэгийг шийдвэрлэж, энгийн хэрнээ үнэтэй хариулт өгчээ. Түүх, улс төрийн шинжлэх ухаан, эдийн засгийн асуудлыг цэгцтэй нэгтгэн өгүүлсэн энэ бүтээл эдийн засгийн тухай бидний ойлголтыг өөрчлөх болно”¹⁵¹ хэмээн Стивэн Левит өгүүлсэн байдаг бол “энэхүү гайхалтай хийгээд уншууртай ном улс төрийн болон эдийн засгийн институцийн хувьсал сайн ч, саар ч байдлаар хэрхэн явагдсаныг харуулсан. Энэ номд улс төрийн болон урьдчилан тааварлашгүй “шийдвэрлэх түүхэн үйл явдал” өрнөснөөр гарах шилжилтийн үйл явцын тухай өгүүлжээ. Ажэмолу, Робинсон нар тухайн шилжилт жам ёсны бүтэцтэй институци бүрэлдэж, шинэ нээлтүүд хийгдэн, эдийн засгийн өсөлт явагдах эсхүл хавчин шахсан институц бүрэлдэж, эцэстээ хөгжил саарч, зогсонги байдалд ороход хүргэсэн шилжилт байв уу гэдгийг түүхэн баримттайгаар өгүүлсэн билээ. Сэтгэл хөдлөм шимшрүүлэм байдлаар үүнийг өгүүлсэн байна” хэмээн Нобелийн шагналт эдийн засагч Роберт Солов өгүүлсэн байдаг.¹⁵² Тэгвэл тэд улс төрийн эдийн засгийн ухаанд бидний анхаарч үзэх ёстой ямар чухал санааг гаргаж тавьсан бэ?

Дарон Ажэмолу, Жеймс А.Робинсон нар А.Смитийн хамгийн чухал хөдөлгөгч хүч гэж үзэж байсан хувь хүмүүсийн хичээл зүтгэл, авьяас чадвар нийгэмд эерэг үр өгөөжөө өгдөг гэдгийг хүлээн зөвшөөрч байсан ч бодит амьдрал дээр улс орон хөгжин цэцэглэх үү, эсвэл мөхөн доройтох уу гэдэг нь төрийн институцээс, тэдний гаргаж байдаг хууль эрх зүйн орчноос л шалтгаална гэж үзсэн юм. Өөрөөр хэлбэл А.Смитийн үзлээс ихээхэн өөр өнцгөөс асуудлыг харсан байдаг. Тэд улс төрийн эрх мэдлийг хязгаарлаж өгөх, түүнийг үр ашигтай хуваарилж өгөх нь эдийн засгийн хөгжлийн урамшуулал болно гэж үзсэн юм. Тэд жишээ нь АНУ-ын эдийн засгийн сайн институцтэй байгаа нь 1619 оноос хойшхи улс төрийн институцийн үйл ажиллагааных нь л үр дүн¹⁵³ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, А.Смит зах зээлийн эдийн засаг чөлөөт өрсөлдөөн бүхнийг зохицуулагч хамгийн чухал зүйл гэж үзэж байсан бол эдгээр судлаачид түүнээс илүү чухал зүйлийг нь төрийн институц, эрх мэдлийн хуваарилалт, хязгаарлалт нь байх болно гэснээрээ ихээхэн ялгаатай байдаг. Ажэмолу, Робинсон нарын онол бол хэдийгээр улс орнуудын эдийн засгийн хөгжлийн үр дүнгийн тухай өгүүлээд байдаг боловч онолын цаад мөн чанар нь улс төрийн тухай онол юм. Өнөөгийн бидний эрэл хайгуулын нүдээр бол жинхэнэ утгаараа улс төрийн эдийн засгийн сургаал юм. Тэд нийгэмд өндөр дээд байр суурь эзлэсэн хэсгүүд улс төрийн ямар институцийг хэвээр хадгалах, ямар институцийг өөрчлөх хүсэлтэй байдгийг ч эдийн засгийн болон улс төрийн институцийн талаас нь зэрэгцүүлсэн. Тэд улс хөгжих эсвэл мөхөхөд институцийн үзүүлэх нөлөө, ядуурал болон хөгжил цэцэглэлтийн эдийн засгийн тухай, институци хэрхэн бүрэлдэж, цаашид хувьсан өөрчлөгддөг, зарим тохиолдолд олон сая иргэд нь туйлын ядуу тарчиг нөхцөлд амьдарч байхад хүртэл өөрчлөлт хийж чаддаггүйн шалтгааныг өгүүлсэн -ядуурал болон хөгжил цэцэглэлтийн бодлогын тухай улс төрийн эдийн засгийн үнэ цэнэтэй бүтээл туурвисан эрдэмтэд билээ.

Улс төрийн эдийн засгийн ухааны нэр хүндтэй, цаг үе бүртээ од мэт гялалзсан эрдэмтэн мэргэдийн бүтээл туурвилаас цухас дурдаж, эргэцүүлэн бодвол бидний зам мөрөө үнэлэх үнэлгээ, юуг өөрчлөх, юуг анхаарах ёстой болох нь илт дурайн харагдах болно. ... Капитализм зөвхөн Өрнөдөд бус газар бүрт амжилтын түүх болох үед бид бодит ертөнцийн зах хязгаараас хальж ирээдүй өөд дүүлэхэд өөрсдийн оюун ухааныг ашиглаж чадах болно гэсэн Э.Сотогийн үгээр энэ өгүүллийг төгсгөж байна. Капитализм Монгол Улсад ч амжилтын түүхээ бичих цаг үе ирэх биз, гэхдээ энэ цаг үе нь бид улс төрийн эдийн засгийн ухааныг жинхэнэ утгаар нь ойлгож, хэрэгжүүлж чадсан тэр үед л ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

¹⁵¹ “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан . Хөгжил, хүчирхэгжил хийгээд арчаагүйтэл, доройтлын сурвалж”. УБ., 2012, Номын тухай хэсэг

¹⁵² Мөн тэнд.

¹⁵³ Дарон Ажэмолу Жеймс А.Робинсон. “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан . Хөгжил, хүчирхэгжил хийгээд арчаагүйтэл, доройтлын сурвалж”. УБ., 2012, 46 дэх тал

Ном зүй.

Адам Смит “Үндэстнүүдийн баялаг.” УБ., 2009

Фредерик Бастиа. “Ил харагдах, үл харагдах УБ., 2014

Дарон Ажэмоу Жеймс А.Робинсон. “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан . Хөгжил, хүчирхэгжил хийгээд арчаагүйтэл, доройтлын сурвалж”. УБ., 2012

Эрнандо дэ Сото. Капиталын нууц. Өрнөдийн яялгуусан капитализм өөр газар өөдлөдөггүйн учир. УБ.2003.

H.Peter Gray. International Economic Problems and Policies. NY., 1987.

JamesMadison8 Alexander Hamilton, and John Jay. Ed. Isaac Kramnick. London,1987.